

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт					
Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ					
2025 он					
д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Нотлох баримт
<b>Засгийн газрын тогтоол</b>					
19	ТӨСЛИЙН НЭГЖИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-10-23 Дугаар 2024_143	2.2."Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн нэгжийг татан буулгахтай холбогдуулан тус нэгжийн чиг үүрэг, эд хөрөнгийг "Монголросцветмет" ТӨҮГ-т шилжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Монголросцветмет" ТӨҮГ (Д.Тогтохсүрэн) нарт даалгасугай.	Засгийн газрын тогтоолыг үндэслэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас төслийн нэгжийн үйл ажиллагаа, чиг үүргийг "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-т шилжүүлэх ажлын хэсэг байгуулсан бөгөөд Үйлдвэрийн газрын Захирлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/283 тоот тушаалаар хөрөнгө тоолох ажлын хэсгийг байгуулсан. Уг ажлын хэсгээс төслийн нэгжийн хөрөнгийг нэг бүрчлэн тоолж актаар баталгаажуулсан бөгөөд хөрөнгө орлогод авах тухай шийдвэр гаргуулах хүсэлтээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлээд байна. 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр хөрөнгө шилжүүлэх тогтоол гаргах талаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтарсан үйлзлэл зохион байгуулсан бөгөөд холбогдох нэмэлт материалыг хүргүүлээд байна. "Эрдэнэс Монгол" нэгдлээс 2025 оны бүтцэд "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийг "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын нэгжийн бүлэглэхийн орлуулсан	100%	
20	Экспортын орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай 2025-02-19 Дугаар 2025_94	1. Төрийн өмчит уул уурхайн компаниудын экспортын орлогыг нэмэгдүүлэх, зардал хэмнэх чиглэлээр цогц арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт)-д даалгасугай.	Экспортын орлогыг нэмэгдүүлэн гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Үйлдвэрийн газрын захирлын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/197 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн нэмэлт төлөвлөгөөг батлан, нэмэлт төлөвлөгөөний биелэлтийг ханган ажилласан байна.	100%	
21		2.2. Томоохон төсөл, арга хэмжээний санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхдээ гадаад валютын улсын нөөцөд богино, дунд, урт хугацаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай.	"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ нь 2025 онд 30.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс батлуулан ажиллаж байгаа бөгөөд улсын гадаад валютын нөөцийг бууруулах хэмжээний том хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөхийг болно.	100%	
22	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг өсгөх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2025-03-19 Дугаар 2025_135	3.1.Ашигт малтмалын олборлолт, баяжуулалт, экспортыг нэмэгдүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, гадаадын хөрөнгө оруулалт татах, урьдчилгаа төлбөр, төслийн санхүүжилт, эсхүл ногоон зээлийн санхүүжилт авах зэргээр "Эрдэнэс Монгол" нэгдлийн хэмжээнд 1.0 тэрбум ам.долларын орлого нэмж төвлөрүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), "Эрдэнэс Тавантолгой" ХХ (Х.Мөнхжаргал), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Г.Ёндон), "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ (Д.Тогтохсүрэн), "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК (Б.Чагнаадорж)-д:	Экспортын орлогыг нэмэгдүүлэн гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Үйлдвэрийн газрын захирлын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/197 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн нэмэлт төлөвлөгөөг батлан, нэмэлт төлөвлөгөөний биелэлтийг хангаар ажиллаж байна. Энэ төлөвлөгөөг 2026 оны дуустал хэрэгжүүлснээр Төрийн хүдрийн Fe-65 баяжмалын экспортыг 129.0 мян.тн, Төрийн хүдрийн Fe-52 баяжмалын экспортыг 63.7 мян.тн, Жоинсны ФФ-95 баяжмалын экспортыг 10.0 мян.тн тус тус нэмэгдүүлж нийт 14.2 сая ам.долларын орлого нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ нь дээрх тогтоолын хүрээнд 14.2 сая ам.долларын орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Тогтоол хэрэгжиж эхэлснээс хойш буюу 2025 оны 12 дүгээр сарын 31-нийг хүртэлх байдлаар Монгол банкинд 92.5 сая ам.доллар мөнгөн хэлбэрээр төвлөрүүлсэн.	100%	
23		3.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан мега төслөөс бусад 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төслүүдийн санхүүжилтийг төлбөрийн тэнцлийн дарамтыг бууруулах зорилгод нийцүүлэн эрэмбэлж, зарим зардлын зохицуулалтын арга хэмжээ авч хөрөнгийн оновчтой, үр ашгийг удирдлагыг хэрэгжүүлэхийг "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), "Эрдэнэс Тавантолгой" ХХ (Х.Мөнхжаргал), "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ (Г.Ёндон), "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ (Д.Тогтохсүрэн), "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК (Б.Чагнаадорж)-д.	"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын зүгээс 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс 0.2 сая ам.долларын үнийн дүн бүхий хөрөнгө оруулалтыг хойшлуулах саналаа өгсөн бөгөөд дээрх үзүүлэлтийг ханган ажиллах төлөвлөгөөтэй байна.	100%	
15	Төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаа, засаглалыг сайжруулах, шинэчлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-08-27 Дугаар 2025_61	5.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, оновчтой тогтоох, удирдлагын зардал, орон тоог бууруулах зорилгоор зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах болон чиг үүргийн давхардалтай, үр ашгийг хуулийн этгээдүүдийг нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах замаар орон тоог 10-аас доошгүй хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардлыг 15-аас доошгүй хувиар бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангуулж, холбогдох шийдвэрийн төслийг Засгийн газрын хуралдаанд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор оруулж, шийдвэрлүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрчис Монгол" ХХК болон хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч нарт тус тус үүрэг болгосугай.	Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ нь 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/146 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан, Холбогдох төлөвлөгөөг боловсруулан, ажиллаж байна.	60%	
16		6.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дэргэдэх нийгмийн шинжтэй, ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, нэгжийг өөрчлөн зохион байгуулах, бие даасан хуулийн этгээдийн хэлбэрт шилжүүлэх, илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг нь хувьчлалаас гадуур худалдан борлуулах талаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Монгол" ХХК, "Эрчис Монгол" ХХК-д тус тус даалгасугай.	Хамааралгүй.		
<b>Ерөнхий сайдын захирамж</b>					
24	Ажлын хэсэг байгуулах тухай 2025-03-13 Дугаар 2025_45	1.Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, хяналт тавих, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, салбар дундын зохицуулалт хийх, Монгол банкин дахь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:	"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ нь дээрх тогтоолын хүрээнд 14.2 сая ам.долларын орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсэн. Таллант хугацаанд буюу 2025 оны 01 дүгээр сарын 01-ээс 2025 оны 12 дүгээр сарын 31-нийг хүртэлх байдлаар Монгол банкинд нийт 112.36 сая ам.доллар мөнгөн хэлбэрээр төвлөрүүлсэн.	100%	
<b>ЗГ-ын тэмдэглэл</b>					
25	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 44 дүгээр тэмдэглэл 2025-01-18 Дугаар 2024_44	44.22.2.2. Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн болон бусад төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын сүүлийн 10 жилийн үйл ажиллагааны ашиг (алдагдал), 2024 оны санхүүгийн нөхцөл байдал, 2025 оны төлөвлөгөө, төсөв, 2028 он хүртэлх зорилтот түвшин талээр нэгдсэн мэдээлэл бэлтгэн Засгийн газрын гишүүдэд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт)-д тус тус;	"Эрдэнэс Монгол" ХХК-иас өгсөн загвар маягтын даруу Үйлдвэрийн газрын сүүлийн 10 жилийн үйл ажиллагааны ашиг, алдагдал санхүүгийн нөхцөл байдал, төсөв, төлөвлөгөөний талаар мэдээлэл боловсруулан Засгийн газрын хуралд танилцуулан.	100%	

26	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-04-09 Дугаар 2025_17</p>	<p>16.20.2.4.. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш дотоодод баяжуулах зорилгоор нээлттэй тендер шалгаруулалтад оролцож уул уурхайн бүтээгдэхүүн худалдан авсан баяжуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа болон тус үйлдвэрүүдийн экспортлох зорилгоор гаалийн хяналтын талбайд байршуулсан бүтээгдэхүүний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дүгнэлт, санал, зөвлөмжид үндэслэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн сайд Б.Жавхлан, Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), "Монголын хөрөнгийн бирж" ХК (Б.Дөлгөөн)-д;</p>	<p>"Эрдэнэс Критикал Минералс ТӨҮГ нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүнийг биржээр борлуулах байгаа.</p>	100%	
	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 09 дугаар сарын 10-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-09-10 Дугаар 2025_16</p>	<p>28.15 Уулын ажилд нэн шаардлагатай тэсрэх бодисын үндсэн түүхий эд болох аммиакийн шүүний импорт багассантай холбогдуулан тэсрэх бодисын нөөцийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор нүүрсний уурхайнуудыг шаардлагатай тэслэгээний мат?риалаар хангах асуудлыг хууль, журмын дагуу нэгдлийн хэмжээнд зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт)-д</p>	<p>"Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын өрөмдлөг тэслэгээний ажлыг туслан гүйцэтгэгчээр хийлгүүлдэг бөгөөд тэсрэх бодис, тэслэгээний хэрэгсэлийн хангамжийн асуудлыг гэрээний дагуу гүйцэтгэгч тал хариуцаж тул нэмэлтээр тэсрэх материал, тэслэгээний хэрэгслийг нөөцлөх шаардлага үүсдэггүй болно</p>	100%	
	<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 14 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-08-27 Дугаар 2025_14</p>	<p>20.2.1 "Эрдэнэс Монгол ХХК, түүний нэгдлийн хэмжээнд борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, хөрөнгө оруулалтыг хойшлуулах замаар 4 их наяд төгрөгийг төвлөрүүлэх болон улс, орон нутгийн төсөвт оруулж, татварын орлого, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), түүнийн нэгдлийн хуулийн этгээдүүдэд.</p>	<p>"Экспортын орлогыг нэмэгдүүлэн гадаад валютын улсын нөөцийг өсгөх зорилгоор Үйлдвэрийн газрын захирлын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/197 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн нэмэлт төлөвлөгөөг батлан, нэмэлт төлөвлөгөөний биелэлтийг хангахаар ажиллаж байна. Энэ төлөвлөгөөг 2026 оныг дуустал хэрэгжүүлснээр Төмрийн хүдрийн Fe-65 баяжмалын экспортыг 129.0 мян.тн, Төмрийн хүдрийн Fe-52 баяжмалын экспортыг 63.7 мян.тн, Жоншны ФФ-95 баяжмалын экспортыг 10.0 мян.тн тус тус нэмэгдүүлж нийт 14.2 сая ам.долларын орлого нэмэгдүүлэхээр төлөвлөсөн. "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ нь дээрх тогтоолын хүрээнд 14.2 сая ам.долларын орлого</p>	100%	
		<p>20.2.1 "Эрдэнэс Монгол" ХХК, түүний нэгдлийн хуулийн этгээдүүдийн засаглал, үр ашгийг сайжруулах хүрээнд бүтцийг оновчтой тогтоох, шинэчлэл хийх зорилгоор үр ашиггүй, чиг үүргийн давхардалтай хуулийн этгээдүүдийг нэгтгэх, татан буулгах, шилжүүлэх, захиргааны болон удирдах ажилтны тоог бууруулах, нэгдлийн хэмжээнд ажлын үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшууллын систем нэвтрүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Монгол" ХХК (С.Наранцогт), түүнийн нэгдлийн хуулийн этгээдүүдэд.</p>	<p>Хэрэгжилтийн хүрээнд "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ нь 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/146 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулан, холбогдох төлөвлөгөөг боловсруулан, ажиллаж байна.</p>	60%	
<b>Эрдэнэс Монгол ХХК Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол</b>					
27	<p>Тогтоол №43 "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшин, бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Компанийн тухай хуулийн 76.1.18, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 95 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 3.2.7.2, 3.2.7.3, "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын дүрмийн 4.1.1, 4.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:</p> <p>1."Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшинд өөрчлөлт оруулан нэгдүгээр хавсралтаар, бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.</p> <p>2.Баталсан 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшинг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын Захирал Д.Тогтохсүрэнд үүрэг болгосугай.</p> <p>3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогтод үүрэг болгосугай.</p>	<p>"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ нь 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшингийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.</p> <p>Үйлдвэрийн газар нь санхүүгийн тайланг улирлаар тооцон гаргадаг бөгөөд 2025 оны 4-р улирлын тайланг сарын санхүүгийн тайлангаар эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшингийн биелэлт, тайланг "Эрдэнэс Монгол" ХХК-д хургуулан ажиллана.</p>	100%	
28	<p>Тогтоол №44 "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын 2025 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай</p>	<p>Компанийн тухай хуулийн 76.1.18, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 95 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 3.2.7.3, "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын дүрмийн 4.1.1, 4.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:</p> <p>1."Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулан нэгдүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.</p> <p>2.Баталсан 2025 оны төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг мөрдөх, хууль тогтоомжийн хүрээнд зарцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын Захирал Д.Тогтохсүрэнд үүрэг болгосугай.</p> <p>3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогтод үүрэг болгосугай.</p>	<p>"Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ нь 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж буй бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд ажиллаж байна.</p> <p>Үйлдвэрийн газар нь 2025 оны эхний хагас жилд 189.6 тэрбум төгрөгийн төсөвтэй ажиллахаар төлөвлөж гүйцэтгэлээр 155.9 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан болно. Нийт зардлын төсөв 33.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.</p> <p>Үйлдвэрийн газрын 2025 оны 4-р улирлын санхүүгийн тайлангийн үр дүнгээр төсвийн гүйцэтгэлийг "Эрдэнэс Монгол" ХХК-д хургуулан ажиллана.</p>	100%	
29	<p>Тогтоол №45 "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай</p>	<p>Компанийн тухай хуулийн 76.1.18, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 95 дугаар тогтоол, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дүрмийн 3.2.7.4, "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын дүрмийн 4.1.1, 4.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:</p> <p>1."Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтцийг хавсралтаар баталсугай.</p> <p>2."Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын нийт орон тооны хязгаарыг 1752 байхаар тогтоосугай.</p> <p>3.Үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ-ын Захирал Д.Тогтохсүрэнд үүрэг болгосугай.</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогтод үүрэг болгосугай.</p> <p>5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Монголросцветмет" ТӨҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний</p>	<p>Тус тогтоол шийдвэрийг үндэслэн "Эрдэнэс Критикал Минералс" ТӨҮГ-ын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Үйлдвэрийн газрын Захиргааны албан тушаалын жагсаалт, харьяа нэгжүүдийн орон тооны дээд хязгаарыг баталсан бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар дундаж хүний тоо 1619 байна.</p>	100%	